

“СИЛК НЭТ” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 02-р сарын 26 өдөр

Дугаар: 18/01/01

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1, 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Силк Нэт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 4-р сарын 27-ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж, Реженс байрны 3-р давхар, 314 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 3-р сарын 20-ний өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон бусад төсөл төлөвлөгөөг батлах
 3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэх
 4. Компанийн үйл ажиллагааны чиглэл болон дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
 5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох
 6. Бусад
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2018 оны 3-р сарын 02-нд болон 2018 оны 03-р дугаар сарын 19-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр, брокерийн компаниудад 2018 оны 3-р сарын 07 өдөр хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2018 оны 4-р сарын 27-ны өдрийн 11 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1, Хуралтай холбоотой танилцвал зохих материалын жагсаалтыг Хавсралт 2-р, Дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг хурлаас өмнө буюу 2018 оны 3-р сарын 13 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /О.Амартүвшин /-д даалгасугай.

8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг нотлох баримтыг үндэслэн компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссийн даргаар Гүйцэтгэх Захирал О.Амартүвшин, гишүүнээр Г.Энхбат, Тооллогын комиссийн даргаар Д.Номин-Эрдэнэ, гишүүнээр У.Халиунаа нарыг тус тус томилсугай.
10. “Силк нэт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ОНОН